

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 05 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**


2025 оны 06 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны 05 дугаар сарын биелэлтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-д заасны дагуу төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилтын 36 арга хэмжээг хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Шинэчлэгдэн батлагдсан журмын хүрээнд хяналт-шинжилгээ хийхэд нийт арга хэмжээний 91.6 хувь нь бүрэн хангалттай буюу 100-85 хувь, 5.5 хувь нь хангалттай буюу 85-70 хувьтай үнэлэгдлээ. (График 1, Хүснэгт 1)

График 1



Хүснэгт 1

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ (хувиар)				Хувь
	Бүрэн хангалттай	Хангалттай	Хангалтгүй	Үнэлгээнд тооцоогүй	Дундаж хувь
	100 хүртэл	85 хүртэл -70-с дээш	70 хүртэл	-	
1	2	3	4	5	6
36	33	2	-	1	97.7

Зорилт тус бүрээр ангилан авч үзвэл Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна” зорилтод тусгагдсан 7 арга хэмжээний дундаж “бүрэн хангалттай” буюу 95.7 хувийн биелэлттэй, Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” зорилтод тусгагдсан 28 арга хэмжээнүүдийн дундаж үнэлгээ нь мөн адил “бүрэн хангалттай” буюу 98.2 хувьтай байна. (График 2, Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна	7	6	-	1	-	-	95.7
2	Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ	28	25	2	1	-	-	98.2
Нийт		35	31	2	2	-	-	96.95
Үнэлгээнд тооцоогүй-1 арга хэмжээ								

График 2



Чиглэл тус бүрээр авч үзвэл Захиргаа, удирдлагын газар, Иргэний харьяаллын газар, Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс төлөвлөсөн арга хэмжээнүүдийн үнэлгээ буурч үр дүнг нэмэгдүүлж, эрчимжүүлэх шаардлагатай бол бусад нэгжийн төлөвлөн хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд бүрэн хэрэгжиж 100 хувиар үнэлэгдсэн. Үнэлгээ буурсан арга хэмжээнд:

Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй боловч үр дүн гарч эхэлж байгаа 2 арга хэмжээ байгаа нь:

- Захиргаа, удирдлагын газар
- Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс

Зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах 2 арга хэмжээ байгаа нь:

- Иргэний харьяаллын газар
- Захиргаа, удирдлагын газар, Зөвлөгөө, мэдээллийн хэлтсийн хамтарсан

Хүснэгт 3

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Захиргаа, удирдлагын газар	13	12	1	-	-	-	99.2
2	Виз, зөвшөөрлийн газар	2	2	-	-	-	-	100
3	Иргэний харьяаллын газар	1	-	-	1	-	-	70
4	Зөрчил шалган шийдвэрлэх газар	3	3	-	-	-	-	100
5	Санхүү, хангалт, үйлчилгээний газар	3	3	-	-	-	-	100
6	Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс	4	3	1	-	-	-	97.5
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс	2	2	-	-	-	-	100
8	Мэдээллийн технологийн хэлтэс	2	2	-	-	-	-	100
9	Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс	2	2	-	-	-	-	100
10	Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	100
11	Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	100
12	Захиргаа, удирдлагын газар, Зөвлөгөө мэдээллийн хэлтэс хамтарсан	1	-	-	1	-	-	70
Нийт		35	31	2	2	-	-	94.7

График 3



Мөн газар хэлтсүүдийн буюу Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1 арга хэмжээ, Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1 арга хэмжээний биелэлт 100 хувьтай бол Захиргаа, удирдлагын газар, Зөвлөгөө, мэдээллийн хэлтсийн хамтарсан 1 арга хэмжээ 70 хувьтай үнэлэгдсэн байна.

Дүгнэлт, зөвлөмж

Байгууллагын 2025 оны 05 дугаар сард төлөвлөн гүйцэтгэсэн 35 арга хэмжээний хэрэгжилт 97.7 хувьтай үнэлэгдлээ. Энэ нь өмнөх сарын үйл ажиллагааны үнэлгээнээс 2.6 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд үнэлгээ буурсан арга хэмжээнүүдийн үр дүнг сайжруулж, өмнөх сарын хяналт-шинжилгээгээр өгсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу газар, нэгжүүд эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээг сайжруулсан эсэх, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлагнаж, дараа сарын байгууллагын үйл ажиллагаанд заавал тусган хэрэгжүүлэх шаардлагатай юм. Үүнд:

1. “Бүрэн хангалттай” буюу 85 буюу түүнээс дээш хувьтай үнэлэгдсэн

Бүгд Найрамдах Солонгос Улсын Хууль зүйн хүрээлэнгийн удирдлагыг хүлээн авах бэлтгэл ажлыг хангах (хэрэгжилт 90 хувь)

-Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс өөрсдөөс шалтгаалах арга хэмжээг авсан ч шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй;

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах (хэрэгжилт 90 хувь)

- Захиргаа, удирдлагын газар нь тухайн арга хэмжээг шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ нийцүүлэн тайлагнах;

2. “Хангалттай” буюу 70-85 хүртэл хувьтай үнэлэгдсэн

Монгол Улсын иргэний харьяаллын талаарх хүсэлтийг хүлээн авч, холбогдох ажиллагааг зохион байгуулах (хэрэгжилт 70 хувь)

-Иргэний харьяаллын газар нь Ерөнхий сайдад танилцуулж зорилтот түвшиндээ бүрэн хүрэх;

Гадаадын иргэний 48 цагийн бүртгэлийн талаарх нөлөөллийн аян зохион байгуулах (хэрэгжилт 70 хувь)

- Захиргаа, удирдлагын газар, Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс нь зорилтот түвшиндээ бүрэн хүрэх талаар зохион байгуулалт, хариуцлагыг нэмэгдүүлэх;

3. “Бүрэн хангалттай” буюу 100 хувьтай үнэлэгдсэн 31 арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр чанаржуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

Мөн байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэгдүгээр зорилгын “Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна”, хоёрдугаар зорилгын “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ” зорилтуудад тусгагдсан арга хэмжээнүүдийг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган үр дүнг нэмэгдүүлж ажиллахыг зөвлөмж болгож байна.

--oo0oo--